



ХУУЛЬ ЭРХ, ЗҮЙН МЭДЭЭЛЭЛ

2025 оны 12-р сар

№60

АКР Хуулийн фирм

Үйлчлүүлэгч та бүхэндээ Шинэ жилийн мэндийг дэвшүүлье. Өнгөрсөн нэг жилийн хугацаанд манай хуулийн фирмтэй хамтран ажилласан та бүхэндээ гүн талархал илэрхийлж байна. Ирж буй 2026 онд үйлчлүүлэгч та бүхний ажил үйлсэд өндрөөс өндөр амжилт хүсье.



Бид энэ оны 4-р улиралд батлагдсан онцлох **ХУУЛЬ ТОГТООМЖ**-с танилцуулж байна.

- ① **2026 оны төсөв, түүнтэй холбогдох бусад хууль тогтоомжууд батлагдлаа. Үүнд:**
 - ✘ Монгол улсын 2026 оны төсвийн тухай
 - ✘ Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хууль
 - ✘ Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай
 - ✘ Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай зэрэг 4 хууль тогтоомж батлагдсан байна.
- ② **2025 оны 11-р сарын 5-ны өдөр Тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийг баталсан.**

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хооронд 2024 оны 10-р сарын 29-ний өдөр байгуулсан "Тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээр"-ийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсан.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- ① 2026 онд Өрийн удирдлагын тухай хуулийн дагуу 561.2 тэрбум төгрөг хүртэлх дотоод үнэт цаас, мөн 1.0 тэрбум ам.доллар хүртэлх гадаад үнэт цаас гаргах асуудлыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэх эрхийг Монгол Улсын Засгийн газарт олгосон.

(УИХ-ын тогтоол, Дугаар 102, 2025.11.14)

- ② Монгол Улсын Үндсэн хуульд заасан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх, түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдох зарчмын хүрээнд зарим арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан. Тавантолгойн бүлэг ордын ашиглагдаагүй байгаа хэсгийг эдийн засгийн эргэлтэд оруулах, орд ашиглалтыг сайжруулж, одоо болон ирээдүйн иргэдийн эрх ашгийг тэгш хангах зарчмыг баримтлан тухайн орд газруудыг урт, удаан хугацаанд үр ашигтай ашиглах бодлого хэрэгжүүлэхийг үүрэг болгосон.

(УИХ-ын тогтоол, Дугаар 103, 2025.11.14)

ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- ① Томуу, томуу төст өвчний дэгдэлтийг бууруулах, өвчний хүндрэлээс сэргийлэх зорилгоор 2025.11.01-с 2026.03.01 хүртэлх хугацаанд томуу, томуу төст өвчнөөр өвчилсөн 6 хүртэлх насны хүүхдээ эмнэлэгт, эсхүл гэрээр асарч байгаа, ажил, хөдөлмөр эрхэлдэг эх, эцэг, асран хамгаалагчид ажлын тав хүртэлх хоногийн цалинтай чөлөө олгохыг төсвийн байгууллагын дарга, захирал нарт даалгаж, хувийн хэвшил нарт уриалсан байна.

(ЗГ-ийн тогтоол, Дугаар 147, 2025.10.29)

- ② "Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам"-д доор дурдсан агуулгатай заалт нэмсэн.

"Нэг удаагийн буцалтгүй тусламж авах эрх бүхий төрийн албан хаагч нас барсан тохиолдолд буцалтгүй тусламжийг Иргэний хуульд заасны дагуу өвлөгчид түүний хүсэлтээр олгоно."

(ЗГ-ийн тогтоол, Дугаар 173, 2025.11.24)

САЙДЫН ТУШААЛ

- ① Албан татвар төлөгчийн орлого олох үйл ажиллагаатай хамааралгүй аж ахуйн нэгжийн нийгмийн хариуцлагын хүрээнд агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнд хөнгөлөлт эдлэх бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг баталсан

(Эрчим хүчний сайдын тушаал, Дугаар А/253, 2025.10.01)

АКР-ИЙН ОНЦЛОХ МЭДЭЭ

- ① Манай фирм нь Монголын Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны гишүүнээр элсэн орсон.



- ② Манай фирм нь Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим-ийн гишүүн байгууллагаар элсэн орсон.



- ③ Манай фирм нь Санхүүгийн зохицуулах хорооноос "Үнэт цаасны зах зээлд зөвлөгөө өгөх зөвшөөрөл"-ийг авсан.



Ингэснээр манай фирм нь Due Diligence Report (DDR) буюу Хууль зүйн магадлан шинжилгээг хийх эрхтэй болж байна.

DDR нь IPO хийх гэж байгаа компани, дотоод өрийн бичиг, бонд гаргах гэж буй, M&A хийх, монгол компанийн хувьцааг худалдан авах гэж буй компаниудын хувьд нэн зайлшгүй хийх шаардлагатай ажил байдаг.

Манай хуулийн фирм нь мэргэжлийн баг хамт олны ур чадвар, туршлага, гадаад хэлний мэдлэгээ ашиглан, хууль зүйн магадлан шинжилгээг хийх болно.

ALISON & KATE PARTNERS

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, Pearl tower A блок 902 тоот
Web: www.akp.mn
E-mail: contact@akp.mn
Tel: 7704-1414